

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/16/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/16/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 82

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмын хамгаалалт зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн ба цагдаа дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх, алба хаагчид тангараг өргөх ёслол болсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27,546.5 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 66,290.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 25 хөтөлбөр, 5 зорилт, 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 28 арга хэмжээг бүрэн, 4 арга хэмжээг 70.0 хувь, 3 арга хэмжээг 30 хувь, нийт дүнгээр 93.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0702900301

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	228,987.63	322,563.78
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,773,492.98	4,528,950.34
	Нийт хөрөнгийн дүн	5,002,480.62	4,851,514.13
	Нийт өр төлбөрийн дүн	-	93.54
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,002,480.62	4,851,420.58
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,002,480.62	4,851,514.13
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,563,223.78	5,603,799.06
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,717,097.38	5,754,859.09
	Үйл ажиллагааны үр дүн	(153,873.60)	(151,060.03)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(153,873.60)	(151,060.03)
	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5,002,480.62	4,851,420.58
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,208,079.22	5,002,480.62
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(51,725.00)	-
	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
	Тайлант оны үр дүн	(153,873.60)	(151,060.03)
	Эцсийн үлдэгдэл	5,002,480.62	4,851,420.58
	Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,395,792.79	5,488,144.15
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,376,266.71	5,450,199.83
	Үйл ажиллагааны ЦМГ	19,526.08	37,944.32
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(8,103.00)	(27,546.50)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	11,423.08	10,397.82
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,423.08
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,423.08	11,433.48
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,333,651.04	5,269,643.03
	Урсгал зардал	3,333,651.04	5,269,643.03
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,333,651.04	5,269,643.03
	Улсын төсвөөс санхүүжих	3,266,966.83	5,198,801.32
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	66,684.21	70,841.71

Гурав. Аудитын илрүүлэлт:**Аудитын илрүүлэлт**

Аудитаар 178,849.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогыг 131,344.9 мянган төгрөгөөр дутуу, зардлыг 23,768.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, 1,595.3 мянган төграгийн цалинтай холбоотой авлагыг тусгаагүй, үнэ төлбөргүйгээр нийлүүлэгдсэн 18,800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна
- **Хууль тогтоомжтой холбоотой:** Сахилгын шийтгэлтэй ажилтанд 341.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшил олгох журам"-ын 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно", 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" заалтыг зөрчсөн байна
- Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 2,204.7 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана" заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад сахилгын шийтгэлтэй ажилтанд олгосон 341.3 мянган төгрөг, амралт цалин давхардуулан олгосон 2,204.7 мянган төгрөгийг төлүүлж залрууллаа.

Залруулагдаагүй нийт 5,219.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,219.8 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрч 5,219.8 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлын төсвөөс 5,219.8 мянган төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заавар" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Ажлаас чөлөөлөгдсөн 6 ажилтантай амралтын цалингийн дуусгалын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоог хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Тоо	Дүн
										тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 23,768.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	23,768.0	-	-	1	23,768.0	1	23,768.0	-	-	-	-
	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогыг 131,344.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	131,344.9	-	-	1	131,344.9	1	131,344.9	-	-	-	-
	Ажилчдаас цалингийн урьдчилгааны 220.0 мянган төгрөгийн, цалингийн өрийн 439.8 мянган төгрөгийн, шүүхийн шийдвэрийн суутгалын 935.5 мянган төгрөгийн авлагыг тус тус нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	1,595.3	-	-	1	1,595.3	1	1,595.3	-	-	-	-
	Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 341.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	341.3	1	341.3	-	-	1	341.3	-	-	-	-
	Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 2,204.7 мянган төгрөгийг олгосон	1	2,204.7	1	2,204.7	-	-	1	2,204.7	-	-	-	-

ГАА-2024/16/НА-СТА-ТШЗ



Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	1	18,800.0	-	1	18,800.0	1	18,800.0	-	-	-
Дүн	6	178,054.2	2	4	175,508.2	6	178,054.2	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нээгээл

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
2										
Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	1		-	-	-	-	1	-	-	-
Эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлын төсвөөс 5,219.8 мянган төгрөгийг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.	1	5,219.8	-	-	1	5,219.8	-	-	-	-
Нийт	2	5,219.8	-	-	1	5,219.8	1	-	-	-



Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
	Тайлант онд 18,247.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна	1	18,247.7			1	18,247.7	-	-	-	-		
	Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 19 газар нь нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй газраас зөрүүтэй.	1	-					1	-	-	-		
Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 1,945.1 мянган төгрөгийн 14, зарлагын 96,320.9 төгрөгийн 7 гүйлгээ, емч, хөрөнгө, мөнгө зарцуулах 54,523.0 мянган төгрөгийн 11 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.	1				1							
Нийт		3	18,247.7	0	-	2	18,247.7	1	-	-	-		